

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
НББТ	Нягтлан бодох бүртгэлийн тухай
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШУА	Шинжлэх ухааны академи
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.21 № 06/565
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтад заасны дагуу Палеонтологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Палеонтологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Палеонтологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Палеонтологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг хүрээлэнгийн захирал Х.Цогбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн балансын данстай холбоотой асуудал, худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт, үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Палеонтологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Палеонтологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 23-аас 2020 оны 2 дугаар сарын 06-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Ол дөш хайрхан аудит” ХХК-ний аудитор Г.Рэнцэнханд аудиторын туслах Б.Удвал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Палеонтологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Ол дөш хайрхан аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн А/18 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Палеонтологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь салбарын шинжлэх ухааныг хөгжүүлэх, судалгаа-боловсруулалтын ажил эрхлэх, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, төсөл хэрэгжүүлэх, инновацыг бий болгож үр дүнг нэвтрүүлэхэд оршино.

Палеонтологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Палеонтологийн онолын суурь судалгаа явуулж, захиалгат болон хамтарсан төслүүдийг гүйцэтгэх замаар судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг шинжлэх ухаанд болон практикт нэвтрүүлэх;
- Бусад эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуульд хийгдэж байгаа судалгаа шинжилгээний болон сургалтын ажилд оролцох, эрдэмтдийн залуу халааг бэлтгэх;
- Олон улс, бүс нутаг, гадаад орнуудын болон дотоодын аж ахуйн нэгж байгууллагатай хамтран судалгаа шинжилгээний ажил хийх, түүний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, худалдах, патентлах, олон улсын байгууллага болон гадаад орнуудаас эрдэмтэн мэргэжилтэн урьж хамтарч ажиллах, өөрийн эрдэмтэн мэргэжилтнийг гадаад орнуудад явуулах асуудлыг шийдвэрлэх;
- Монгол орны эртний сээр нуруутны палеонтологи, сэрээ нуруугүйтэйн палеонтологи, палеоботаникийн палеонтологи, регионал геологи, тектоник, магматизм, металлогени ба геодинамикийн гэсэн үндсэн чиглэлүүдээр судалгаа боловсруулалтын ажлыг явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Палеонтологийн хүрээлэнгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн А/40 дугаар тушаалаар баталсан.

Палеонтологийн хүрээлэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашиглаж байна.

Палеонтологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Палеонтологийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 2 эрсдэлтэй асуудалд 4 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд нийт зардлыг сонгосон суурь үзүүлэлт нь 2 хүрээлэн болж шинээр зохион байгуулагдаж, батлагдсан төсвийн дүн 213,667.1 мянган төгрөгөөс тооцон 2,136.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин 553,170.3 мянган төгрөгөөр тооцсон нь нэмэлт санхүүжилтийн данснаас зардал гарсантай холбоотой байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 328 дугаар тогтоолоор Палеонтологи, геологийн хүрээлэнг 2 хүрээлэн болгож зохион байгуулсан бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 430 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг хэрэгжүүлсэн байна.

Шинээр зохион байгуулагдсан Палеонтологийн хүрээлэн нь оны эцэст мөнгөн хөрөнгө 366,601.6 мянга, авлага 11.6 мянга, урьдчилж гарсан зардал 14,042.7 мянга, бараа материал 154,646.6 мянга, үндсэн хөрөнгө 3,820,797.0 мянга, нийт 4,356,099.5 мянган төгрөгийн хөрөнгөтэй байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуульд зааснаар Палеонтологийн хүрээлэн тайлант онд 6,820.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 3,149.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 53.8 хувь буюу 3,671.5 мянган төгрөгөөр тасалсан байна.

Хүснэгт 2. Өөрийн орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	6,820.7	3,149.2	3,671.5	53.8
Нийт дүн	6,820.7	3,149.2	3,671.5	53.8

Тайлант онд Төсвийн шууд захирагч үр дүнгийн гэрээг Төсвийн төвлөрүүлэн захирагчтай 8 чиглэлээр 21, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээ байгуулж, үр дүнгийн гэрээний биелэлт бүрэн хангалттай буюу 97.4 хувиар дүгнүүлж, ШУА-ийн “Шилдэг захирал”-аар шалгарсан байна.

Төсөл арга хэмжээний хөтөлбөрт зориулан 217,812.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 214,141.3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 210,992.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 6,820.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг 53.8 хувь буюу 3,671.5 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Урсгал зардалд нийт 214,141.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэлээр 212,808.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,332.6 мянган төгрөгийг Сангийн Яамны Төрийн сангийн нэгдсэн дансанд буцааж төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 23,854.4 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 910,800.2 мянга, нийт 934,654.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнд

- Урьд оны төвлөрүүлсэн үлдэгдэл 598,621.2 мянган төгрөг;
- Дээд шатны төсвийн захирагчаас 23,854.4 мянган төгрөг;
- “Соёлын өвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8-д заасны дагуу палеонтологийн хайгуул, малтлага, судалгааны ажлын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт хайгуул болон ашиглалтын талбайд үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласны үр дүнд 163,861.2 мянган төгрөг;
- ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн болон Япон улсын “Эн Эйч Кей” Групп, “Гоби суппортс Жапан” ХХК хооронд байгуулсан гэрээний дагуу Япон улсын Токио хотын Үндэсний байгалийн шинжлэлийн музейд 2019 оны 7-10 сарын хооронд зохиогдсон “ДИНОЗАВР ЭКСПО-2019” үзэсгэлэнд Монгол улс 14 олдвороор оролцож, 3 сарын хугацаатай ажилласан уг үзэсгэлэнгээс 148,317.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж ажилласан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас. Үүнээс: Гэрээт ажлын хөлсөнд 127,045.6, нийгмийн даатгалын шимтгэлд 15,520.3, ном хэвлэл 34,537.6, урсгал засварт 61,360.1, багаж, техник хэрэгсэл авахад 234,760.0, томилолт зочны зардалд 49,922.1, бусдаар гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний төлбөрт 19,577.4, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 25,329.9, нийт 568,053.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Томоохон дүн бүхий зардлын гүйлгээнээс: ТӨБЗГ-ын 2019 оны 480, А-1/3904 тоот зөвшөөрлийн дагуу 234.760.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 4 багц тендерийг цахим хэлбэрээр зарлан, шалгаруулж худалдан авсан байна. Тендерийн үнэлгээ хороо нь 5 гишүүнтэй, гишүүн бүр нь ТӨБЗГ-ын А-3 гэрчилгээтэй, 2 нь хөндлөнгийн төлөөлөл байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй талаар Менежментийн захидлын 3.2-т харуулсан болно.

Үлдэгдэл 372,336.6 мянган төгрөгөөс улсын төсөвт 5,736.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл 366,601.6 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй талаар тодруулахад: Сангийн Яамны Төрийн сангийн нэгдсэн дансанд байгаа үзэсгэлэнгийн орлогын 100900015901 дансны үлдэгдлийг төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 156,051.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 154,646.5 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд

1. Стаус программаар санхүүгийн байдлын тайлан дахь үзүүлэлтийн тулгалт болон уялдааг шалгахад: санхүүгийн байдлын тайлангийн нийт бараа материалын эцсийн үлдэгдэл, Бараа материалын тодруулгын үлдэгдэл 154,646.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан заавартай нийцэхгүй, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ тухай хуулийн 15 дугаар зүйл, НББ-ийн алдааг залруулах, 15.1" ААН, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." 15.2" НББ-ийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу залруулга хийлгэсэн.

Аудитаар илэрсэн 1,405.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Урьдчилж төлсөн зардлыг 2020 оны санхүүгийн тайланд авч үзнэ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Палеонтологийн хүрээлэнгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 14 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нэг зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Палеонтологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Палеонтологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Завсрын аудитаар 35,521.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 34,116.9 мянган төгрөгийн залруулгыг жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн, 1,405.0 мянган төгрөгийн залруулгыг 2020 оны 1 дүгээр улиралд залруулахаар хариу ирүүлсэн. Энэ нь бараа материалын данснаас Үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэх учраас ТӨБЗГ-аас зөвшөөрлөөр шилжүүлдэг, зөвшөөрлийг 2020 оны 1 дүгээр улиралд шийдвэрлэхээр болсон байна.

Энэ нь үнэн зөв, бодиттой оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС-1, УСНББОУС-12, УСНББОУС-17, НББ-ийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Хөрөнгийг буруу ангилж бүртгэсэн байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг зөв ангилж бүртгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, зөвлөмж өглөө

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

ТӨБЗГ-аас 2020 оны 1 дүгээр улиралд шилжүүлэх зөвшөөрөл өгөхөөр болсон тул 2020 оны 1 дүгээр улиралд залруулга хийнэ.

3.2 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

3.2.1 Илрүүлэлт:

Захиалагч тендерийн урилгыг худалдан авах ажиллагааны цахим систем хэрэгслээр нийтэд зарлан мэдээлсэн. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т "Хүлээн авсан бүх тендерийг тендерийн баримт бичигт заасан газар, товлосон хугацаанд нийтийн өмнө нээх

бөгөөд тендер нээх хугацааг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 1 цагийн дотор байхаар товлону" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь үнэн зөв батламж мэдэгдлийг хангаагүй, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 26.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.2.2 Эрсдэл:

ТБОНӨХБАҮХАТ хуулийг бүрэн мөрдөж ажиллаагүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Үнэлгээний хорооны гишүүдийн дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өглөө.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

ТШЗ хүлээн зөвшөөрсөн хариу ирүүлсэн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	535,302,469.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	366,601,620.39
312	Банканд байгаа бэлэн мөнгө	00.00	366,601,620.39
3121	Төгрөг	00.00	366,601,620.39
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	366,601,620.39
33	АВЛАГА	00.00	11,595.99
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	11,595.99
34	УРЬДЧИЛГАА	00.00	14,042,681.19
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	12,074,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	00.00	1,968,681.19
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	00.00	1,968,681.19
35	БАРАА МАТЕРИАЛ	00.00	154,646,572.33
351	Түүхий эд материал	00.00	3,031,250.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	3,031,250.00
354	Хангамжийн материал	00.00	151,615,322.33
35410	Бичиг хэргийн материал	00.00	4,199,909.01
35420	Аж ахуйн материал	00.00	116,283,578.65
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	2,902,000.00
35450	Барилгын засварын материал	00.00	14,727,330.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	13,502,504.67
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	3,820,796,982.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	00.00	3,820,796,982.14
392	Биет хөрөнгө	00.00	3,621,605,165.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	1,255,322,429.26
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-10,099,561.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	123,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	00.00	131,011,550.19
39206	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-4,455,623.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	00.00	40,838,457.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-1,181,634.87
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	00.00	2,065,195,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	19,003,371.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-907,687.84
39217	Ном	00.00	3,878,865.05
393	Биет бус хөрөнгө	00.00	199,191,816.69
39301	Программ хангамж	00.00	19,389,750.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-904,416.67
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	216,847,780.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-36,141,296.64
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	00.00	4,356,099,452.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	00.00	4,356,099,452.04
51	Засгийн газрын хувь оролцоо	00.00	4,356,099,452.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	00.00	3,649,354,717.94
51101	Өмч: - төрийн	00.00	
512	Хуримтлагдсан үр дүн	00.00	706,744,734.10
51210	Өмнөх үеийн үр дүн	00.00	-3,650,787,854.94
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	4,357,532,589.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	00.00	4,356,099,452.04

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	00.00	4,951,516,663.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	3,800,133,911.96
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	3,800,133,911.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	3,800,133,911.96
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,149,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	3,796,984,711.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	1,151,382,751.87
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	210,992,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	210,992,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	940,390,651.87
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	23,854,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	916,536,251.87
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	00.00	584,585,786.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	584,585,786.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	550,183,317.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	294,289,350.05
210101	Үндсэн цалин	00.00	145,831,436.98
210102	Нэмэгдэл	00.00	14,888,267.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	6,524,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	127,045,646.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	35,907,794.28
210201	Тэтгэврийн даатгал	00.00	26,739,231.81
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,279,501.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	2,156,727.78
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	505,528.66
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	3,226,804.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	3,127,107.22
210301	Гэрэл, цахилгаан	00.00	1,918,836.00
210302	Түлш, халаалт	00.00	868,249.12
210303	Цэвэр, бохир ус	00.00	340,022.10
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	30,601,797.97
210401	Бичиг хэрэг	00.00	8,395,339.43
210402	Тээвэр, шатахуун	00.00	8,970,620.81
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	243,197.47
210404	Ном, хэвлэл	00.00	744,059.93
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	520,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	716,830.33
210408	Бараа материал акталсны зардал	00.00	11,011,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	70,287,882.00
210604	Урсгал засвар	00.00	70,287,882.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	44,412,813.64
210701	Гадаад албан томилолт	00.00	13,836,184.00
210702	Дотоод албан томилолт	00.00	30,576,629.64
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	7,287,335.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	7,138,335.00

Палеонтологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	81,000.00
210807	Газрын төлбөр	00.00	68,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	64,269,237.26
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	10,349,790.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	00.00	53,919,447.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	34,402,468.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	27,333,862.32
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	27,333,862.32
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	7,068,606.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,332,601.30
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,736,005.20
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	00.00	4,366,930,877.59
	Үйл ажиллагааны бус зардлын дүн (V)	00.00	9,398,288.55
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	9,398,288.55
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI)=IV-V)	00.00	-9,398,288.55
	НИЙТ ҮР ДҮН (VII)=(III)+(VI)	00.00	4,357,532,589.04

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	00.00	1,154,531,951.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	3,149,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	3,149,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	3,149,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,149,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	1,151,382,751.87
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	210,992,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	210,992,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	940,390,651.87
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	23,854,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	916,536,251.87
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	00.00	553,170,331.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	553,170,331.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	518,767,862.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	294,300,946.05
210101	Үндсэн цалин	00.00	128,027,799.99
210102	Нэмэгдэл	00.00	29,087,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	10,140,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	127,045,646.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	35,907,794.28
210201	Тэтгэврийн даатгал	00.00	29,900,236.97
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,691,752.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,340,602.39
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	270,472.85
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,704,729.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	3,460,456.22
210301	Гэрэл, цахилгаан	00.00	2,252,185.00
210302	Түлш, халаалт	00.00	868,249.12
210303	Цэвэр, бохир ус	00.00	340,022.10
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	38,349,692.47
210401	Бичиг хэрэг	00.00	1,759,925.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	550,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	243,197.47
210404	Ном, хэвлэл	00.00	34,537,550.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	520,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	739,020.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	62,570,072.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,210,000.00
210604	Урсгал засвар	00.00	61,360,072.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	64,688,563.63
210701	Гадаад албан томилолт	00.00	25,910,184.00
210702	Дотоод албан томилолт	00.00	38,778,379.63
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	9,140,548.00

Палеонтологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	7,691,760.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	81,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	200,000.00
210807	Газрын төлбөр	00.00	1,167,788.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	10,349,790.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	10,349,790.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	34,402,468.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	27,333,862.32
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	27,333,862.32
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	7,068,606.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,332,601.30
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,736,005.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	601,361,620.40
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	234,760,000.01
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	234,760,000.01
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	234,760,000.01
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	234,760,000.01
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-234,760,000.01
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	366,601,620.39
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	366,601,620.39

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-3,650,787,854.94	-3,650,787,854.94
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		-3,650,787,854.94	-3,650,787,854.94
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	3,649,354,717.94	00.00	3,649,354,717.94
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	4,357,532,589.04	4,357,532,589.04
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,649,354,717.94	706,744,734.10	4,356,099,452.04

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	217,812,800.00	212,808,698.70	-5,004,101.30	97.7
УРСГАЛ ЗАРДАЛ	217,812,800.00	212,808,698.70	-5,004,101.30	97.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	215,806,800.00	210,804,698.70	-5,002,101.30	97.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,401,000.00	167,255,299.99	-4,145,700.01	97.6
Үндсэн цалин	132,173,500.00	128,027,799.99	-4,145,700.01	96.9
Нэмэгдэл	29,087,100.00	29,087,100.00	0.00	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	10,140,400.00	10,140,400.00	0.00	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,624,300.00	20,387,457.64	-236,842.36	98.9
Тэтгэврийн даатгал	10,338,400.00	14,379,900.33	4,041,500.33	139.1
Тэтгэмжийн даатгал	2,372,100.00	1,691,752.98	-680,347.02	71.3
ҮОМШӨ-ний даатгал	2,020,900.00	1,340,602.39	-680,297.61	66.3
Ажилгүйдлийн даатгал	654,500.00	270,472.85	-384,027.15	41.3
Эрүүл мэндийн даатгал	5,238,400.00	2,704,729.09	-2,533,670.91	51.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,566,000.00	3,460,456.22	-105,543.78	97.0
Гэрэл, цахилгаан	928,800.00	2,252,185.00	1,323,385.00	242.5
Түлш, халаалт	952,400.00	868,249.12	-84,150.88	91.2
Цэвэр, бохир ус	1,684,800.00	340,022.10	-1,344,777.90	20.2
Хангамж, бараа материалын зардал	3,367,300.00	3,367,297.47	-2.53	100.0
Бичиг хэрэг	701,900.00	1,534,500.00	832,600.00	218.6
Тээвэр, шатахуун	550,000.00	550,000.00	0.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,075,800.00	243,197.47	-832,602.53	22.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	520,000.00	520,000.00	0.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	519,600.00	519,600.00	0.00	100.0
Томилолт, зочны зардал	14,916,600.00	14,766,499.38	-150,100.62	99.0
Дотоод албан томилолт	14,916,600.00	14,766,499.38	-150,100.62	99.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,931,600.00	1,567,688.00	-363,912.00	81.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	469,100.00	465,000.00	-4,100.00	99.1
Даатгалын үйлчилгээ	356,600.00		-356,600.00	0.0
Тээврийн хэрэгслийн татвар	2,900.00	2,900.00	0.00	100.0
Газрын төлбөр	1,103,000.00	1,099,788.00	-3,212.00	99.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,006,000.00	2,004,000.00	-2,000.00	99.9
Бусад урсгал шилжүүлэг	2,006,000.00	2,004,000.00	-2,000.00	99.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,006,000.00	2,004,000.00	-2,000.00	99.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	217,812,800.00	212,808,698.70	-5,004,101.30	97.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	210,992,100.00	209,659,498.70	-1,332,601.30	99.4
Улсын төсвөөс санхүүжих	210,992,100.00	209,659,498.70	-1,332,601.30	99.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,820,700.00	3,149,200.00	-3,671,500.00	46.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,320,700.00	3,149,200.00	-3,171,500.00	49.8

Палеонтологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	-		
БАЙГУУЛЛАГЫН ТОО				
Төсвийн байгууллага	1	1		
АЖИЛЛАГСАДЫН ТОО	47	47		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	41	41		
Үйлчлэх ажилтан	5	5		

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	00.00	573,789,031.48
УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	573,789,031.48
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	542,723,163.96
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	127,045,646.06
Гэрээт ажлын хөлс	00.00	127,045,646.06
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	15,520,336.64
Тэтгэврийн даатгал	00.00	15,520,336.64
Хангамж, бараа материалын зардал	00.00	34,982,395.00
Бичиг хэрэг	00.00	225,425.00
Ном, хэвлэл	00.00	34,537,550.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	219,420.00
Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	282,330,072.01
Багаж, техник, хэрэгсэл	00.00	216,140,000.00
Тавилга	00.00	4,830,000.01
Урсгал засвар	00.00	61,360,072.00
Томилолт, зочны зардал	00.00	49,922,064.25
Гадаад албан томилолт	00.00	25,910,184.00
Дотоод албан томилолт	00.00	24,011,880.25
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	22,572,860.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	7,226,760.00
Тээврийн хэрэгслийн татвар	00.00	78,100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	15,200,000.00
Газрын төлбөр	00.00	68,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	10,349,790.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	10,349,790.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	31,065,867.52
Бусад урсгал шилжүүлэг	00.00	25,329,862.32
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	25,329,862.32
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		5,736,005.20
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		5,736,005.20
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	940,390,651.87
Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	940,390,651.87
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	23,854,400.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	916,536,251.87
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00	366,601,620.39
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	366,601,620.39

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.02.03	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:		Палеонтологийн хүрээлэн		САГ-2020/158/СТА-ТШЗ
				Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
2	Бараа материалыг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн	1.4	ТӨБЗГ-аас 2020 оны 1 дүгээр улиралд шилжүүлэх зөвшөөрөл өгөхөөр болсон тул зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Х.Цогтбаатар А.Санжханд
3	ТБОНӨХБАУХАТ хуулийг мөрдөн ажиллаагүй байх		Үнэлгээний хорооны гишүүдийн дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Х.Цогтбаатар А.Санжханд
	Дүн	1.4			